



НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 8/з

Улаанбаатар хот

“Цэвэр орчин-ая тух” аян зохион
байгуулах тухай

Монгол улсын засгийн газрын 2019 оны 204 дүгээр “Журам батлах тухай” тогтоол, 2019 оны Эрүүл мэндийн сайдын “Заавар батлах тухай” А/537, 2017 оны А/505, “Түр заавар шинэчлэн батлах тухай 2022 оны А/36 дугаар тушаал тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үйлчилгээний ажилчдын өдрийг угтаж “Цэвэр орчин-Ая тух” сэдэвт аяныг 2022 оны 04-р сарын 11-ний өдрөөс 2022 оны 04-р сарын 24-ний хооронд бүх тасаг нэгжүүдийн үйлчилгээний ажилтнуудын дунд зохион байгуулан явуулсугай.

2. “Цэвэр орчин-Ая тух” сэдэвт аяны ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, аяны удирдамжийг хоёрдугаар, аяныг дүгнэх шалгуур үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аяны ажлыг чанартай зохион байгуулан ажлын хэсгийг удирдлага, арга зүйгээр хангаж үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга/ Ц.Энхбаясгалан/-д даалгасугай.

4. Аяны үйл ажиллагаанд тасаг нэгжийнхээ үйлчилгээний ажилтнуудыг идэвхтэй оролцуулж халдварын эрсдэлээс сэргийлэх чиглэлээр тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллахыг Аж ахуйн албаны дарга, хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч наарт үүрэг болгосугай.

5. Үйлчилгээч, асрагч, туслах ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

6. Тус аяны үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг байгууллагын зохих төсвээс гаргахыг ахлах нягтлан бодогч / С.Оюун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

7. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга/ Д.Гэжиймаа/-д даалгасугай.

ДАРГА

Э.БОДЬЦЭЦЭГ

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
... оны ... дүгээр сарын ... ны өдрийн
... -р тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|-------------------------|------------------------------------|
| 1. Ажлын хэсгийн ахлагч | С.Өлзийжаргал-тархвар судлаач |
| 2. Гишүүд: | Т.Дэлгэрмаа-Аж ахуйн албаны дарга |
| | 3. Уранчимэг-ХЭТ-ийн эрхлэгч |
| | Ц.Оюунчимэг –Чанарын менежер |
| | Д.Бат-Эрдэнэ-Хүний нөөцийн ажилтан |

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2022 оны 04 дугээр сарын 08-ны өдрийн
04.22-р тушаалын хоёрдугаар хавсралт

“ЦЭВЭР ОРЧИН-АЯ ТУХ” СЭДЭВТ АЯНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг: Үндэслэл:

Эмнэлэгийн орчинд цэвэр цэмцгэр байдлыг хадгалах үйл явц бол цэвэрлэгээ юм.

Эмнэлгийн орчныг цэвэр байлгаснаар ажиллагсдын болон үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангаж аливаа өвчлөл, эрсдлээс сэргийлэх нөхцлийг бүрдүүлнэ.

Сайн гүйцэтгэсэн цэвэрлэгээ үйлчилгээ нь ажиллагсад болон үйлчлүүлэгчдэд сэтгэл хангалиун ажиллах, эмчлүүлэх, үйлчлүүлэх сонирхлыг бүрдүүлдэг байна.

Хоёр. Зорилго:

ЭМТ-ийн тасаг нэгжүүдийн цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвартын эрсдлээс сэргийлэх, ая тухтай цэвэр орчныг бүрдүүлэх

Гурав. Хамрах хүрээ:

ЭМТ-ийн Хэвтэн эмчлүүлэх тасаг, амбулатори, ЗАА-н тасгийн үйлчилгээний ажилтнууд

Дөрөв . Хугацаа:

2022 оны 04-р сарын 11-24-ний хооронд

Тав: Аяны хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлын чиглэл

- Хуваарьт тасаг нэгждээ их цэвэрлэгээ хийж өдөр тутмын цэвэрлэгээг холбогдох заавар журмын дагуу гүйцэтгэж тэмдэглэл хөтөлсөн байх
- Цэвэрлэгээний хувин сав, алчуур, шалны мод зэргийг таних тэмдэгжүүлэн зориулалтын дагуу хэрэглэж хэвшсэн байх
- Цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах болон ая тухтай аюулгүй орчныг бүрдүүлэхэд шинэлэг арга барилыг нэвтрүүлэн ажилласан байх
- Үйлчилгээний ажилтнуудын дунд халдвартын сэргийлэлт, хөдөлмөр аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулсан байх
- Үйлчилгээний ажилтнуудад гарын авлага бэлтгэж өгөх
- Үйлчилгээний ажилтнуудыг шалгаруулах үнэлгээний шалгуурыг гаргаж үнэлнэ.

Зургаа: Шалгаруулалт урамшуулалт

Аяны ажлын үр дүнг 2022 оны 4-р сарын 22-23-ны хооронд ажлын хэсгийн гишүүд шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж онооны дарааллаар байр эзлүүлэн шалгаруулж урамшууллыг олгоно .

1. 1-р байр— Θргөмжлөл 1 сарын цалингаар
2. 2-р байр- Θргөмжлөл сарын цалингийн 80%-иар
3. 3-р байр ---- Θргөмжлөл сарын цалингийн 50%-иар

Удирдамж боловсруулсан:

Тархвар судлаач:

С.Өлзийжаргал

Чанарын менежер:

Ц.Оюунчимэг

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
 дээд оны Өндүгээр сарын Өдрийн
 Агаар тушаалын гуравдугаар хавсралт

АЯНЫГ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Оноо / 0-5 / Нийт 40 ондоо
---	------------------	-------------------------------

Нэг. Үйлчлэгч асрагч, угаагч нарыг үнэлэх шалгуур

- 1 Ажлын цаг ашиглалт
- 2 Хуваарьт тасаг нэгждээ их цэвэрлэгээ хийж өдөр тутмын цэвэрлэгээг холбогдох заавар журмын дагуу гүйцэтгэн тэмдэглэл хөтөлсөн байдал
- 3 Цэвэрлэгээний хувин сав, алчуур, шалны мод зэргийг таних тэмдэгжүүлсэн байдал
- 4 Өөрийн үйл ажиллагаандaa шинээр санаачилж хийсэн ажил, үр дүн
- 5 Ажлын хувцсыг зааврын дагуу зөв өмсөж хэвшсэн байдал
- 6 Харьцаа хандлагын талаар гомдол санал гаргаагүй байх
- 7 Цэвэрлэгээ үйлчилгээтэй холбоотой гомдол санал гаргаагүй байх
- 8 Сургалт зохион байгуулсан байх

Хоёр Жолооч нарыг үнэлэх шалгуур

- 1 Ажлын цаг ашиглалт
- 2 Машиндаа цэвэрлэгээ халдвартгуйжүүлэлт хийх хувин сав материал хэрэгслийг бүрдүүлж тавьсан байдал
- 3 Машины аюулгүй байдал, тусlamж үйлчилгээтэй холбоотой тоног төхөөрмжүүдийг бүрэн бүрдүүлсэн байдал
- 4 Машины дотор тал болон тоног төхөөрөмж хэрэгслүүддээ цэвэрлэгээ халдвартгуйтгэлийг тогтмол хийж хэвшсэн байдал
- 5 Жолоочийн замын хуудсыг цаг тухайд нь бүрэн хөтөлж хэвшсэн байдал
- 6 Өөрийн үйл ажиллагаандaa шинээр санаачилж хийсэн ажил, үр дүн
- 7 Харьцаа хандлагын талаар гомдол санал гаргаагүй байх
- 8 Үйлчилгээтэй холбоотой санал гомдол гаргаагүй байх

Гурав. Бусад туслах ажилчид /

- 1 Ажлын цаг ашиглалт
- 2 Ажлын байр цэвэр, эмх цэгцтэй байх
- 3 Хийж гүйцэтгэсэн ажлын талаар тэмдэглэл хөтөлдөг байх

4	Өөрийн үйл ажиллагаандаа шинээр санаачилж хийсэн ажил, үр дүн	
5	Ажлын хувцсыг зааврын дагуу зөв өмсөж хэвшсэн байдал	
6	Харьцаа хандлагын талаар гомдол санал гаргаагүй байх	
7	Үйлчилгээтэй холбоотой санал гомдол гарваагүй байх	
8.	Засвар үйлчилгээ, хангалтуудыг цаг хугацаанд нь бүрэн хийдэг байх	